

СЭНДЛИ ББСБ НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот

Хурлын төрөл: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
Хурлын огноо: 2024 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр
Хуралдсан газар: УБ хот, Blue sky Tower-ын 2 давхарт, Emerald танхимд болон цахимаар
Хурал эхэлсэн цаг: 12:00

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг танилцуулна. Үүнд:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлан;
2. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр;

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэж, шийдвэрлүүлнэ. Үүнд:

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсөв батлах;

Хөтлөгч: Сайн байцгаана уу? Сэндли ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Хурлыг эхлүүлнэ үү хэмээн өнөөдрийн хурлын даргаар ажиллаж байгаа Сэндли хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Наранбат таныг урьж байна.

Б.Наранбат: Сайн байцгаана уу? “Сэндли ББСБ” Нээлттэй хувьцаат компанийн нийт хувьцаа эзэмшигчдэд энэ өдрийн мэнд хүргэе. Сэндли ББСБ нь нээлттэй хувьцаат компани болон хэлбэрээ өөрчилснөөс хойш бүртгэлийн өдрийн байдлаар 6864 хувьцаа эзэмшигчтэй болсон байна. Компанийн ХЭ-ийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах шийдвэрийг холбогдох хууль, журмыг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 19-ны өдөр хуралдаж, 05 тоот тогтоолоор шийдвэрлэсэн. Хувьцаа эзэмшигчдийн хурал бол компанийн эрх барих хамгийн дээд байгууллага байдаг. Энэ удаагийн хурлыг танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж байна. Ингээд Монгол орны өнцөг булан бүрээс цахимаар оролцож байгаа болон энд хүрэлцэн ирсэн та бүхэнд талархлаа илэрхийлэн, Сэндли ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурал нээснийг мэдэгдье. Ингээд та бүхэнд хурлын дэгийг танилцуулъя.

Хурлын дарга Б.Наранбат хурлыг эхлүүлж, хурлын дэгийг танилцуулав.

Хөтлөгч: Өнөөдрийн хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулсан хурлын дарга Б.Наранбат танд баярлалаа. Ингээд Хувьцаа эзэмшигчдийн ирцийн мэдээлэл гарсан байна. Тооллогын комиссын дарга А.Итгэлт танилцуулна.

А.Итгэлт: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Ингээд Сэндли ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн мэдээллийг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулъя.

“СЭНДЛИ ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2024 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

*Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
хүчин төгөлдөр болсныг батлах тухай*



Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1 дэх заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, 2024 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Сэндли ББСБ” ХК-ийн 2024 оны “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр 2024 оны 3 дугаар сарын 15-ны өдөр байсныг дурдсугай.
2. Бүртгэлийн өдрөөр “Сэндли ББСБ” ХК-ийн нийт саналын эрхтэй хувьцааны тоо 223,570,000 ширхэг байснаас 2024 оны “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-д 159,133,088 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирснээр нийт саналын эрхтэй хувьцааны 71.18 % болж, хурлын ирц бүрдсэнийг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлсүгэй.
3. Хурлын ирц 71.18 % болж, хурлын ирц бүрдсэн тул “Сэндли ББСБ” ХК-ийн 2024 оны “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал” хүчин төгөлдөр болсныг зөвшөөрч баталсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

А.ИТГЭЛТ

Хөтлөгч: Хурлын ирцийг танилцуулсан Тооллогын комиссын дарга А.Итгэлт танд баярлалаа. Холбогдох хуулийн дагуу хурлын ирц хүчин төгөлдөр болсон байх тул бид хурлаа хөтөлбөрийн дагуу хурлаа үргэлжлүүлэн хурлын үндсэн хэсэгт шилжье. Сэндли ББСБ ХК-ийн 2024 оны ээлжит хурлаар танилцуулах асуудал болох Сэндли ББСБ ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны тайлан болон аудитлагдсан санхүүгийн тайлан, Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг танилцуулна уу хэмээн Хурлын дарга Б.Наранбат таныг дахин урьж байна.

Б.Наранбат: Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар “Сэндли ББСБ” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны тайлан болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулна.
/компанийн 2023 оны үйл ажиллагаа болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулав/

Та бүхэн компанийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлантай танилцлаа. Бид анх IPO хийхдээ ногдол ашгийн бодлогоо цэвэр ашгийн 20%-ийг тараахаар тусгасан. Энэхүү бодлогынхоо хүрээнд 2022 оны цэвэр ашгийн 20,064%-ийг буюу 614,817,500 төгрөгийг тарааж байсан бол 2023 онд цэвэр ашгийн 20.6755% буюу 1,251,991,232.27 төгрөгийг тараахаар Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн хурлаар шийдвэрлэсэн. */Ногдол ашигтай холбоотой ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулав/*

Хөтлөгч. Та бүхэн танилцуулсан асуудлуудтай холбоотойгоор асуулт, хариултын цагийг эхлүүлж байна.

Хувьцаа эзэмшигчдээс асуулт асуув.

Хувьцаа эзэмшигч: Сайн байна уу? Намайг Оюун гэдэг. Бүх зүйл ойлгомжтой байна. Түрүү жил ч гэсэн бид ойлголтоо авсан. Манай Сэндли компани бүх мэдээллээ ил тод, нээлттэйгээр үргэлж өгч байдаг. Өчигдөр гэхэд үндэсний ТВ-р холбогдох мэдээллээ авсан. Баярлалаа. Ингээд хэдэн асуулт байна. Брокерийн компаниудтай манай компани хир холбоотой ажилладаг вэ? Брокерийн компаниуд Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгөх үүрэгтэй гол байгууллага байдаг боловч зарим брокеруудын хувьд хувьцаа эзэмшигчдийг тухай бүрийн мэдээллээр хангадаггүй. Тэгэхээр бид брокеруудыг хэрхэн яаж сонговол ашигтай байдаг вэ? Та бүхэн брокеруудтай хэрхэн яаж ажилладаг вэ?

Мөн Монгол улсад Сэндли компанитай ижил төстэй үйл ажиллагаатай өрсөлдөгч компаниуд гэж ямар ямар компаниуд байдаг вэ? Энэ талаар мэдээлэл, төсөөлөл өгөхийг хүсье. Сүүлийн асуултын хувьд компанийн логоны утга учрыг тайлбарлаж өгнө үү. Одоо хүртэл логоны утга учраа сайн ойлгож мэдээгүй байна. Баярлалаа.

Б.Наранбат: Монгол Улсад үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй 50-д компани байдаг. Энэ дундаас андеррайтер буюу бусдаас хөрөнгө босгож өгөх эрхтэй буюу дүрмийн сан 2 тэрбум байх шаардлагыг хангасан 15 орчим компани байгаа. Бидний хувьд хамгийн туршлагатай компаниуд болох Өлзийбаяр захиралтай Өлзий энд Ко компани, Цэвэгмид захиралтай Райнос инвестмент компани болон Голомт капитал гэсэн андеррайтерын компаниудтай хамтран ажиллаж байна. Манай харилцагч нарын эрх ашгийн хамгаалах, мэдээллээ зөв түгээх сайн компанийг сонгох гэж анхнаасаа хичээсэн. Монгол улсын иргэн хэд хэдэн газар үнэт цаасны данстай байж болно эсхүл нэг компани руу дансаа шилжүүлэх боломжтой. Энэ утгаараа та бүхэн манай сонгон хамтран ажиллаж байгаа эдгээр компаниудыг сонгох боломжтой. Мөн манай Сэндли компанитай зэрэгцээ компани буюу Монголын финтек группийн охин компани болох үнэт цаасны Стоклав секьюритиз компани байдаг. Стоклав секьюритиз компанийн хувьд илүү технологийн хувьд тэргүүлэгч байхыг зорьж ажилладаг. Өөрөөр хэлбэл, та бүхэн цалингийн картын дансаа холболоо гэхэд, сар бүр, жил бүр гэх мэт сонголтоор тогтмол хувьцааны худалдан авалт хийх боломжтой буюу аль болох таны гар оролцоог багасгасан, туршигдсан шинэ технологийг нэвтрүүлэн ажиллаж байгаа. Хоёрдахь асуултын хувьд манай логоны тайлбарын тухайд “зогсолтгүй эргэх хүч” гэсэн агуулгыг илэрхийлдэг. Харин сүүлийн асуулт болох өрсөлдөгч компаниудын тухайд бол Монгол улсын хэмжээнд хамгийн том ББСБ бол Инвескор гэж компани байдаг. Тус компани 2017 онд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд бидэнд маш зөв зам заасан, боломжтойг харуулсан ББСБ гэж хардаг. Иймд бид хэмжээгээрээ хоцрохгүйн тулд IPO хийж та бүгдтэй нэгдэж нийлсэн. Миний ойлгож байгаагаар ББСБ-ийн зах зээлийн 10 орчим хувийг эзэлж байгаа, Харин Сэндли -ийн хувьд 1.5%-ийг эзэлж байна. Бидэнд Инвескор компанитай зэрэгцэж очих буюу активын хэмжээгээ 10 дахин нэмэгдүүлэх буюу өнөөдрийн танилцуулсан 63 тэрбумын хөрөнгийг 630 тэрбум төгрөг болгох, 43 тэрбумын зээлийг 430 тэрбум төгрөг болгох боломж бололцоо нээлттэй байгаа. Мөн бид тус Инвескор компаниас өөр нэг зүйлийг суралцах хэрэгтэй. Инвескорын жилийн ашиг 40 тэрбумаас дээшээ гараад эхэлсэн байгаа. Гэтэл монголд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны 12 банк байгаа, жижиг банкуудын хувьд 10 тэрбумаас доошоо байна. Энэ нь хэрэв хүнээс хөрөнгө татаж байгаа бол тэр мөнгө үржигддэг, ажилладаг байх ёстой, ББСБ нь банкнаасаа илүү ашигтай ажилладаг болсон гэдгийг Инвескор бидэнд харуулж чадаж байна. Бид үүнээс суралцах болно. Бид өрсөлдөгчөө гэхээс илүү ББСБ-д нь бие биедээ илүү дэмтэй, тустай, хүндлэлтэй явдаг.

Харин мөнгөн гуйвуулгын хувьд бидэнтэй төстэй нэртэй сэнд мн гэж компани байдаг. Тус компанийн хувьд манай сэндли-ийн дараа буюу сарын дараа сэнд мн болон зах зээлд гарч ирсэн. Уг нь бол өмнө нь өөр нэртэй байсан. Манай компанийн зүгээс сэндли болон сэнд-тэй нэрүүдийг авч оюуны өмчийн газарт бүртгүүлсэн. Иймд бид тус компанид нэрээ сольж зах зээлд хэрэглэгчдийг төөрөгдүүлэхгүй байхыг удаа дараа хүссэн боловч шийдвэрлээгүй тул одоог хүртэл оюуны өмчийн маргаантай явж байна. Манай 6000 гаран хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг нэгтгэсэн Сэндли компань жилд 500 саяас тэрбум төгрөг хүртэлх маркетингийн зардал гаргаж байхад олон нийтэд мэдээлэл болж очихдоо мөнгөн гуйвуулга хийдэг сэнд-тэй компани байдаг гэж бусдад төөрөгдөл үүсгэж, зардал хуваагдаж байгаа учраас бид гомдлоо гаргасан. Үүнд оюуны өмчийн газраас сэндли-ийн зөв байнаа, сэнд мн нэрээ өөрчил гээд шийдвэрээ гаргасан. Гэвч нөгөө тал маань тус шийдвэрийг гаргасан байцаагчийн эсрэг гомдол гарган шүүхдээд явж байна. Иймд бид энэ дээр бууж өгөхгүй, шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллах болно. Баярлалаа.

Хувьцаа эзэмшигч: Сайн байна уу? Хувьцаа эзэмшигч Сүхбаатар гэж хүн байна. Өнөөдөр компанийнхаа өнгөрсөн оны ажлын тайлан, цаашдын зорилтыг сонсож танилцаад сэтгэл хангалуун байна. Миний зүгээс 2 зүйлийг тодруулъя. Нэгдүгээрт, АНУ-с хийх мөнгөн гуйвуулга маань 2 сар тасалдсан гэж хэлсэн. Үүнийг нэг компанийн үйл ажиллагаанаас хамааруулахгүйгээр 2 компанитай хамтран ажиллах ч юмуу ямар нэг байдлаар энэ тал дээр ажилламаар байна гэж санагдаж байна. Үүн дээр цаашид ямар ажил хийгдэх вэ? Энэ зөвхөн

АНУ биш, бусад орнуудад ч ийм тасалдал гарахыг үгүйсгэхгүй нь байна шүү дээ. Мөн дараагийн асуулт нь анх IPO гаргаж байх үед Хайпэй компани IPO гаргана гэж Б.Наранбат захирал хэлж байсан. Миний бодлоор үйл ажиллагаагаа ингэж 2-3 хувааж, ажиллах хүчээ тарамдуулж байснаас нэг болгоод явбал хувьцаа эзэмшиж байгаа бидний хувьд сайнаар нөлөөлөх болов уу гэж санагддаг юм. Гэхдээ цаанаа бас тусгай зөвшөөрөлтэй холбоотой юм байна гэдгийг ойлгосон. Иймд ямар гаргалгаа байгаа вэ? Хайпэй дээрээ IPO гэхгүйгээр компаниудаа нэгтгэх арга хэмжээний талаар цаашдаа ямар төлөвлөгөөтэй байгааг тодруулж өгнө үү. Баярлалаа.

Б.Наранбат: Мөнгөн гуйвуулгын хувьд бид хичээж ажиллах болно гэдгээ илэрхийлж байна. Биднээс хамаарахгүй хүчин зүйлс бас байгаа. Бид дандаа олон улсын харилцаа холбооны ажил хийж байгаа. Тэр болгон дээр цаад түншүүдийн маань нөхцөл байдлаас хамаарч байгаа зүйлс гарч байна. Богино хугацаанд нэг орон дээр олон түнш сонгож чадахгүй байгаа зовлон бас байна. Нөгөө талдаа маш олон хүний хүчээр хийх ажлыг цөөн хүний хүчээр, цөөн чадварлаг боловсон хүчний ачаар хийж байгаа учраас хүн хүчний дутагдалтай асуудал бас байдаг. Бас нэг чухал хүчин зүйл бол бид байнгын тэлэлт хийж байгаа. Тэлэлт хийж шинэ бүтээгдэхүүнээр шинэ зах зээлийг нээхийг зорин ажиллаж байгаа хэдий ч өмнөх зүйлс дээрээ бэхжүүлэлтээ, тогтворжуулалтаа хаяхгүй шүү гээд явж байгаа. Энэ бүхэн маань ачааллыг нэмж байна. Гэхдээ миний ингэж хэлж байгаа нь үүсч байгаа нөхцөл байдлуудыг маань ойлгоорой гэж хэлж байгаа болохоос алдаа бол зайлшгүй гарна гээд хэнэггүй хандаж байгаа зүйл биш гэдгийг ойлгоорой. Хөрөнгө оруулагчаас маань гадна харилцагчдад маань асуудал гарч байгаа юм шүү.

Хайпэй компани дээр IPO гаргах тухай ярьж байсан. Бид энэ сарын 29-ний өдөр толгой компани болон Монголын финтек групп компани дээрээ хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийнэ. Тус компани бол Сэндли-тэй ижил хувьцаат компани боловч хөрөнгийн бирж дээр хувьцаа нь арилжаалагддаггүй хаалттай хувьцаат компани юм. Ийнхүү хаалттай хувьцаат компани болохдоо бид 3 зүйлийг хэлж байсан. Нэгт бид Сэндли дээр IPO хийнэ, үнэ цэнийг өсгөнө, үүний дараа Хайпэй дээр IPO хийнэ, үнэ цэнийг өсгөнө. Түүний дараа эдгээрийн хувьцааг эзэмшиж байгаа Монголын финтек групп компанийг нээлттэй хувьцаат компани болгон IPO хийж, үнэ цэнийг өсгөнө гэж ярьж байсан. Үүнийхээ дагуу хийх болов уу гэж бодож байгаа. Таны хэлснээр Хайпэй, Сэндли-г нэгтгэж үндсэн нэг брэндтэй явах, хүн хүчээ тарамдуулахгүй байх гэдгийг ойлгож байна. Хүн хүчний тарамдалт маань харьцангуй гаагүй гэдгийг хэлий. Учир нь бид нэгдсэн нэг оффистой тул бид байнгын хамтын ажиллагаатай хамт байдаг учраас тус тусдаа компани мэт боловч нэг цул гэж ойлгож болно. Тусдаа брэнд байх нь харилцагч талдаа зардалтай бас харилцагч төөрөгдөх асуудлууд гарч байгаа. Нэгдэж, нийлэхийн хувьд бодлого нь зөв гэдгийг бид маш сайн ойлгож байгаа. IPO хийсэн Сэндли-тэй IPO хийгээгүй Хайпэй нэгдэх үү, эсхүл Хайпэй IPO хийсний дараа IPO хийсэн Сэндли-тэй нэгдэх үү гэх мэт маш олон хувилбарууд байгаа. Мэдээж энэ бүхний шийдвэрийг хувьцаа эзэмшигч та бүхэн гаргана. Мөн нэгдэж, нийлэх үедээ тухайлчлан аль компанийнхаа үнэ цэнэ ямар байна, зах зээлийн үнэлгээ хир байна гэдгээс хамаарна. Хайпэй-ийн хувьд ялгарал гэх зүйл нь өндөр байгаа учраас илүү өндөр хүлээлттэй байна. Alipay-с хойш хүмүүс маш их сонирхож байна. Толгой компани маань 100 хувь эзэмшиж байгаад сарын өмнө бид 10 хувиа ажилчдадаа хувьцаагаа эзэмшүүлэхээр шийдвэрлэж сэндли-тэй ижил “Хайпэй эмплойе” буюу ажилчдын эзэмшдэг компани болгохоор болсон. Ямар ч тохиолдолд бидэнд боломж байна, эдгээр боломжуудаа хэрхэн хооронд нь уялдуулах вэ, хэрхэн талуудын эрх ашгаа хохироохгүйгээр ажиллах вэ гэдэг нь бидний шийдэж болох асуудал юм. Аль ч тохиолдолд нь та бүхний эрх ашгийг өндөрт өргөсөн шийдвэр байх болно. Учир нь та бүгдийг сэтгэл ханамжтай байлгах нь бидний үүрэг юм. Тэгэж байж бидний дараа дараагийн боломжууд нээгдэх юм. Асуулт асуусан та бүхэнд баярлалаа.

Хөтлөгч: Асуулт асуусан хувьцаа эзэмшигчдэдээ баярлалаа. Хэрэв та тус асуултын цагт багтаан асуулт асууж амжаагүй эсхүл дахин нэмэлт тодруулах зүйлс байвал завсарлагааны үеэр эсхүл хурлын дараа хурлын даргатай биечлэн уулзаж асуух боломжтой. Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар нийт 2 асуудлыг та бүхний санал хураалтаар шийдвэрлэнэ. Санал хураалт явагдах асуудлыг танилцуулахаас өмнө та бүхэнд саналаа хэрхэн өгөх талаар зааврыг танилцуулъя.

Хувьцаа эзэмшигчдийн хуралд Санал өгөх заавар бичлэгийг танилцуулав.

Б.Наранбат: Та бүхэн саналаа хэрхэн өгөх талаар ойлголттой болсон гэж бодож байна. Ингээд шийдвэрлэх 2 асуудлыг танилцуулъя. Танилцуулж байх хугацаанд та бүхэн саналаа өгөх бүрэн боломжтой. Би та бүхэнд ямар томъёоллын дагуу санал хураах вэ гэдгийг танилцуулъя.

Нэгдүгээр асуудлын хувьд, та бүхэнд танилцуулсан компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөл хуралдан дүгнэлт гаргасан бөгөөд энэхүү дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлах хуулийн шаардлага байдаг.

/гарах шийдвэрийн төслийг танилцуулав./

Хоёрдугаар асуудлын хувьд, ТУЗ-ийн 2024 оны жилийн төсвийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батална. Үүнд ТУЗ-ийн хурлын зардал, ТУЗ-ийн гишүүдийн цалингийн зардал, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалингийн зардал багтаж байгаа болно. Үүнд бид зөвхөн үндсэн цалинг 500,000 төгрөг байсныг 1 сая төгрөг болгон нэмэгдүүлж, бусад зардлыг хэвээр үлдээж байгаа. Учир нь ижил төстэй бусад ХК-ийн ТУЗ-ийн цалинтай эн зэрэгцүүлэхийг хичээж байгаа хэдий ч эхний ээлжинд өөрсдийн боломж бололцооны хүрээнд ийнхүү нэмэгдүүлэх саналыг гаргаж байна.

/гарах шийдвэрийн төслийг танилцуулав./

Та бүхэнд санал хураалт явагдах 2 асуудлыг танилцууллаа. Та бүхэн саналаа идэвхитэй өгөхийг хүсч байна. Санал хураалтын дүн гарах хүртэл та бүхэн буффетээр үйлчлүүлэн ард байгаа цай, кофе уух боломжтой. Санал өгөх талаар туслалцаа хэрэгтэй тохиолдолд манай компанийн ажилчид та бүхэнд туслах болно.

ЗАВСАРЛАГА /20 минут үргэлжилж, энэ хугацаанд санал хураалтын үйл ажиллагаа явагдав/

Хөтлөгч: Санал хураалтын шугам хаагдсан байна. Үүгээр санал хураалт явагдаж дууссан тул санал хураалтын дүнг уншиж танилцуулна уу хэмээн Тооллогын комиссын дарга А.Итгэлтийг урьж байна.

А.Итгэлт: Хувьцаа эзэмшигчдийн санал хураалтын дүн гарлаа. Та бүхэн танилцуулъя.

“СЭНДЛИ ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудал тус бүрийн саналын дүнг нэгтгэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.8 дахь заалт, 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Сэндли ББСБ” ХК-ийн “2023 оны үйл ажиллагаа болон аудитлагдсан санхүүгийн тайланд гаргасан Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай” асуудлыг хуралд оролцсон саналын эрхтэй 159,133,088 ширхэг хувьцаанаас 158,637,699 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигч буюу 99.69% зөвшөөрсөн санал, 495,389 ширхэг энгийн хувьцаа эзэмшигч буюу 0.31% нь түдгэлзсэн санал ба татгалзсан санал байхгүй байх тул санал хураалтыг хүчинтэйд тооцсугай.
2. “Сэндли ББСБ” ХК-ийн “Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны төсвийг батлах тухай” асуудлыг хуралд оролцсон саналын эрхтэй 159,133,088 ширхэг хувьцаанаас 158,732,818 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигч буюу 99.7485% зөвшөөрсөн санал, 111 ширхэг энгийн хувьцаа эзэмшигч буюу 0.00007% татгалзсан санал, 400,159 ширхэг энгийн хувьцаа эзэмшигч буюу 0,25143% нь түдгэлзсэн санал өгсөн байх тул санал хураалтыг хүчинтэйд тооцсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

А.ИТГЭЛТ

А.Итгэлт: Санал хураалтын дүнтэй танилцлаа. Энэхүү хурлаар үндсэн хоёр асуудлыг шийдвэрлэсэн бөгөөд гарах шийдвэрийн төслийг танилцуулья.
/шийдвэрийг уншиж танилцуулав/

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2024.04.03

№ 01

Улаанбаатар хот

Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Сэндли ББСБ” ХК-ийн дүрмийн холбогдох заалт, компанийн 2024 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 01 тоот тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Сэндли ББСБ” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн 04 тоот тогтоолоор өгсөн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.НАРАНБАТ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2024.04.03

№ 02

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК-ийн дүрмийн холбогдох заалт, компанийн 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Сэндли ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсвийг Хавсралтаар баталсугай.
2. Энэхүү шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.НАРАНБАТ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНЫ ТӨСӨВ

Үндсэн утга		ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ		
		Нэг сар /төгрөгөөр/	Гишүүдийн тоо	Нийт дүн /төгрөгөөр/
Тогтмол цалин	Гишүүдийн үндсэн цалин	1,000,000	9	108,000,000
	ТУЗ-ийн даргын нэмэгдэл	200,000	1	2,400,000
	Хорооны даргын нэмэгдэл	200,000	3	7,200,000
	Нарийн бичгийн даргын цалин	1,000,000	1	12,000,000
Оролцоонд үндэслэсэн цалин	Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд оролцсон	250,000 /улиралд нэг удаа/	9	9,000,000
Бусад зардал	Хурал зохион байгуулахтай холбоотой зардал			2,000,000 /нэг жил/
НИЙТ				140,600,000

Хөтлөгч: Ийнхүү өнөөдрийн хурлын хөтөлбөр маань дуусч байна. Хурлыг хааж үг хэлнэ үү хэмээн хурлын дарга Б.Наранбатыг дахин урьж байна.

Б.Наранбат: “Сэндли ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар үндсэн хоёр асуудлыг хэлэлцэн баталснаар бид хурлаа амжилттай хийж дуусгалаа. 2024 онд бид бүхэн маш олон зүйлийг хийж бүтээхээр төлөвлөж байна. Дараа жилийн өдийд бид дахин ээлжит хурлаа хийхдээ олон олон амжилтуудыг гарган ажилласан байх болно. Хувьцаа эзэмшигчдийн хуралдаа идэвхтэй оролцож, өөрсдийн үнэт саналаа өгсөн та бүхэндээ баярлалаа. 2024 ондоо, энэхүү луу жилдээ та бүхний ажил амьдралд сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Компанийн цаашдын үйл ажиллагаанд та бүгдийн оролцоо юу юунаас илүү чухал гэдгийг энэ дашрамд хэлмээр байна. Ийнхүү “Сэндли ББСБ” ХК-ийн өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал өндөрлөснийг мэдэгдье.

ШИЙДВЭРЛЭСЭН АСУУДАЛ:

- Компанийн 2023 оны үйл ажиллагаа болон аудитлагдсан санхүүгийн тайланд гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг батлав.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
158,637,699	99.69%	0	0%	495,389	0.31%

- Компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2024 оны төсөв батлав.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
158,732,818	99.7485%	111	0.00007%	400,159	0,25143%

Хурлын дарга Б.НАРАНБАТ /...../

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Э.Цэлмэг /...../